

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 25/12

Улаанбаатар хот

### Компанийн бодлогын баримт бичиг батлах тухай

Компанийн тухай хуулийн 76.1.13, 76.1.18, Компанийн дүрмийн 8.12.13, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоол, ТУЗ-ийн 2025 оны 05-р сарын 14-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Бодь Даатгал ХК-д дагаж мөрдөх “Комплайнсын хяналтын заавар”-ийг Хавсралт № 1-р баталсугай.
2. Бодь Даатгал ХК-д дагаж мөрдөх “Бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогын баримт бичиг”-ийг Хавсралт № 2-р баталсугай.
3. Бодь Даатгал ХК-д дагаж мөрдөх “Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөр”-ийг Хавсралт № 3-р баталсугай.
4. Бодь Даатгал ХК-д дагаж мөрдөх “Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам”-ийг Хавсралт № 4-р баталсугай.
5. Компанийн Гүйцэтгэх захирал болон холбогдох албан тушаалтуудад батлагдсан дүрэм, журм, бодлогыг чанд мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.
6. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор Ш.Бэжидэд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



Б.БИЛЭГТ



**БОДЬ ДААТГАЛ**  
ЭРСДЭЛИЙГ ДАВАХ ХҮҮ

## БОДЬ ДААТГАЛ ХК-ИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧТАЙ ХАРИЛЦАХ ХӨТӨЛБӨР

ТУЗ-ийн 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн  
*25/12* тоот тогтоолын хавсралт *3*



Бодь даатгал ХК	
Баримт бичгийн төрөл:	Хөтөлбөр
Хөтөлбөр:	Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөр
Боловсруулсан нэгж:	Дотоод хяналтын алба
Хэрэгжүүлэх нэгж:	Бүх газар нэгж
Хэрэгжилтэд хяналт тавих нэгж:	Дотоод аудит
Нууцын зэрэг:	/В/ Компанийн дотоод хэрэгцээнд нууц биш
Журмын дугаар:	
Хүчинтэй хугацаа:	Эхлэх: ТУЗ-ийн тогтоол гарснаар Дуусах: ТУЗ-ийн тогтоол хүчингүй болсонд тооцох хүртэл
Хуудасны тоо:	8

	Нэр	Албан тушаал	Гарын үсэг
<b>Бэлтгэсэн:</b>	Д.Наранцэцэг	ДХХХ-ийн ажилтан	
<b>Санал өгсөн:</b>	Э.Бямбажав А.Энхжаргал М.Мөнхбаатар	ТУЗ-ын хараат бус гишүүн Гүйцэтгэх захирал БХГ-ын захирал	
<b>Баталсан:</b>	Б.Билэгт	ТУЗ-ын дарга	
<b>Баталсан огноо:</b>	2025.05.14	<b>Ангилал:</b>	Дотоодын хэрэгцээнд

**ХӨТӨЛБӨРИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ**

№	Хөтөлбөрийн дугаар	Батлагдсан огноо/ тушаалын дугаар	Нэмэлт, өөрчлөлт орсон огноо/ тушаалын дугаар	Цуцлагдсан огноо/ тушаалын дугаар
1				
2				
3				

---

АГУУЛГА	
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	5
ХОЁР. НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР	5
ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ	5
ДӨРӨВ. БАРИМТЛАХ ЗАРЧИМ	5
ТАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДТАЙ ХАРИЛЦАХ,	6
МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ	6
ЗУРГАА. МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭХ СУВАГ	7
ДОЛОО. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН САНАЛ, ХҮСЭЛТ, ГОМДЛЫГ ХҮЛЭЭН АВАХ, ШИЙДВЭРЛЭХ	7
НАЙМ. ХАРИУЦЛАГА	8
ЕС. ХЯНАЛТ	8



## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөр /цаашид “Хөтөлбөр”/-ийн зорилго нь Бодь даатгал ХК /цаашид “Компани”/-ийн хөрөнгө оруулагчдад Компанийн үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц үйл явдал, Компанийн засаглал, стратегийн хэрэгжилт, хэтийн төлөв, санхүүгийн гүйцэтгэл, шаардлагатай бусад санхүүгийн мэдээллийг хүргэх, мэдээлэл солилцохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хөрөнгө оруулагчдад тогтмол хугацаанд үнэн зөв мэдээлэл хүргэх, хөрөнгө оруулагчдаас санал, хүсэлт хүлээн авах, мэдээлэл солилцоход чиглэнэ.
- 1.3. Энэхүү хөтөлбөрт өөрчлөлт оруулах, шинэчлэх эрхийг ТУЗ хэрэгжүүлнэ.

## ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

- 2.1. Хөрөнгө оруулагч: Компанийн гаргасан хувьцаа, бонд зэрэг үнэт цаасыг эзэмшигч, гадаад дотоодын хөрөнгө оруулагчийг хэлнэ. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд хөрөнгө оруулагч гэдэгт хувьцаа эзэмшигч нарыг мөн адил хамруулан ойлгоно.
- 2.2. Хувьцаа эзэмшигч: Компанийн гаргасан хувьцааг эзэмшиж буй хувь хүн болон хуулийн этгээдийг хэлнэ.
- 2.3. Оролцогч талууд: Компанийн хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, ажилтан, харилцагч, олон нийт, төрийн байгууллага гэх мэт компанид сонирхол илэрхийлэгч бүх талуудыг хэлнэ.

## ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ

- 3.1. Оролцогч талуудад компанийн бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн болон байгаль орчин нийгэм засаглалын үзүүлэлтүүд, үйл ажиллагааны хэтийн төлөвийн талаарх үнэн зөв мэдээллийг тогтмол хүргэх;
- 3.2. Хөрөнгө оруулагч нарын оролцоог хангах, компанийн үйл ажиллагааны талаар илүү их ойлголттой болох боломжийг олгох;
- 3.3. Хөрөнгө оруулагч нарын санал хүсэлт, гомдлыг хүлээн авч тухай бүр шийдвэрлэн хамтран ажиллах;

## ДӨРӨВ. БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- 4.1. Хөрөнгө оруулагч нарт мэдээлэл бэлтгэн хүргэхэд дараах зарчмыг баримтална.  
Үүнд:
  - 4.1.1 Мэдээллийг үнэн зөв, ойлгомжтой илэрхийлэн бэлтгэх: Компанийн санхүүгийн болон санхүүгийн бус үйл ажиллагаа, олон нийтэд нээлттэй хүргэх мэдээ мэдээллийг үнэн зөв, хоёрдмол утга агуулаагүй, бүрэн гүйцэд байдлаар бэлтгэнэ.

- 4.1.2 Мэдээллийг хуульд заасан хугацаанд хүргэх: Олон нийтэд нээлттэй, тогтмол хүргэх мэдээ мэдээллийг хууль тогтоомж болон зохицуулагч байгууллагаас үүрэг болгосон хугацаанд төрийн эрх бүхий байгууллагад хүргүүлж, олон нийтэд нээлттэй байршуулах замаар хүргэнэ.
- 4.1.3 Мэдээллийг хүртээмжтэй сувгаар түгээх: Компанийн зүгээс олон нийтэд мэдээлэл хүргэх цахим сувгийг хөгжүүлэн, тасралтгүй сайжруулж ажиллахаас гадна оролцогч талуудад компанийн нээлттэй мэдээлэлд хандах, түүнтэй танилцах нөхцөлөөр хангана.
- 4.1.4 Мэдээлэлд тогтмол нэмэлт, өөрчлөлт оруулах: Хууль тогтоомж болон эдийн засгийн нөхцөл байдал, компанийн үйл ажиллагаанд орсон өөрчлөлт зэргээс шалтгаалан өмнө нь олон нийтэд нээлттэй байршуулан хүргэсэн мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд тухай бүр холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулна.
- 4.2. Хөрөнгө оруулагч нартай харилцах, санал хүсэлт, гомдол хүлээн авах, шийдвэрлэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:
- 4.2.1 Оролцоог хангах: Хөрөнгө оруулагч нарыг компанийн үйл ажиллагааны талаар мэдээлэл авах, үйл ажиллагаатай танилцах, санал хүсэлт, гомдол гаргах, шийдвэрлүүлэх боломжоор хангана.
- 4.2.2 Найрсаг хүндэтгэлтэй хандах: Хөрөнгө оруулагч нартай харилцах, тэдний санал хүсэлт, гомдлыг хүлээн авахдаа эелдэг найрсаг харилцаж, хүндэтгэлтэй хандана.
- 4.2.3 Хариуцлагатай шийдвэрлэх, хяналт тавих: Хүлээн авсан санал хүсэлт, гомдлыг зорилго, тулгарсан асуудлыг анхааралтай сонсож ойлгох, яриаг нь тасалдуулахгүй байх, тодорхойгүй байгаа зүйлсийг нэмж тодруулан асууна.

#### **ТАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДТАЙ ХАРИЛЦАХ, МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ**

- 5.1. Компани нь хөрөнгө оруулагчдад дараах мэдээллийг компанийн цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тухай бүр хүргэнэ.
- 5.1.1 Жилийн болон хагас жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан;
- 5.1.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, мэдэгдэл, хурлын материал;
- 5.1.3 Хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргалтад нөлөө үзүүлэхүйц бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагаанд бий болсон нөхцөл байдалтай холбоотой мэдээлэл
- 5.1.4 Зах зээлийн судалгаа, шинжээчийн дүгнэлт;
- 5.1.5 Хөрөнгө оруулагчдын ирүүлсэн санал хүсэлт, гомдол болон шийдвэрлэсэн байдал;
- 5.1.6 Компанийн шаардлагатай бусад мэдээлэл;

- 5.2. Компани нь дараах хэлбэрээр хөрөнгө оруулагчидтай харилцана.
- 5.2.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр Компанийн санхүүгийн гүйцэтгэл, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/, Гүйцэтгэх захирал, хөндлөнгийн аудиторын тайлан болон хурлын шийдвэрийн төслийг хэлэлцэж, санал авах, асуулга зохион байгуулах;
  - 5.2.2 Цахимаар болон биечлэн санал хүсэлт, гомдлыг хүлээн авах;
  - 5.2.3 Цахимаар болон биечлэн мэдээлэл хүргэх, солилцох;
  - 5.2.4 Бусад арга хэрэгслээр мэдээлэл солилцох;

### **ЗУРГАА. МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭХ СУВАГ**

- 6.1. Хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх үндсэн суваг нь компанийн албан ёсны цахим хуудас /<https://bodi-insurance.com/about/> болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас <https://mse.mn/mn/company/554> байна.
- 6.2. Компанийн албан ёсны цахим хуудсанд хөрөнгө оруулагчдад зориулсан цэсийг гарган хөгжүүлж, компанийн санхүү үр дүн, үйл ажиллагааны тайлан, хувьцааны ханш, ногдол ашгийн мэдээлэл болон шаардлагатай цаг үеийн мэдээ мэдээллийг тогтмол оруулан, шинэчлэн ажиллана.
- 6.3. Шаардлагатай тохиолдолд компанийн албан ёсны сошиал хуудас “Бодь даатгал-Bodi insurance” болон холбоо харилцааны хэрэгслүүд, олон нийтийн мэдээллийн сувгуудыг ашиглан олон нийтэд хүргэнэ.
- 6.4. Олон нийтэд ил тод мэдээлэх мэдээллээс бусад мэдээлэл буюу хөрөнгө оруулагчдаас ирүүлсэн санал хүсэлтийн дагуу мэдээлэл хүргэх тохиолдолд хөрөнгө оруулагчдад хэвлэмэл хэлбэрээр гарт хүргэх, албан ёсны цахим шуудангийн хаягаар нь илгээх арга хэлбэрээр тохиромжтойг нь сонгон хүргэнэ.
- 6.5. Хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх суваг, арга хэлбэрийг тасралтгүй хөгжүүлэн сайжруулна.

### **ДОЛОО. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН САНАЛ, ХҮСЭЛТ, ГОМДЛЫГ ХҮЛЭЭН АВАХ, ШИЙДВЭРЛЭХ**

- 7.1. Хөрөнгө оруулагчдаас санал хүсэлт, гомдлыг дараах сувгаар хүлээн авна. Үүнд:
  - 7.1.1 Компанийн албан ёсны цахим хуудас: [info@bodi-insurance.com](mailto:info@bodi-insurance.com)
  - 7.1.2 Утсаар: 97675054800;
  - 7.1.3 Албан бичгээр: Бодь даатгал ХК-ийн албан ёсны шуудангийн хаягаар;
  - 7.1.4 Биечлэн ирж: Бодь даатгал ХК-ийн төв оффисын Богд цамхаг 12-р давхарт ТУЗ-ийн нарийн бичгийн дарга;
- 7.2. Хөрөнгө оруулагчаас ирүүлсэн санал хүсэлт, гомдлыг тэр даруй ТУЗ-ийн нарийн бичгийн даргад хүргүүлэх бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь нөхцөл байдлыг тодруулж, компанийн холбогдох албан тушаалтантай хамтран шийдвэрлэнэ.
- 7.3. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь хөрөнгө оруулагчаас ирүүлсэн санал хүсэлт, гомдлыг шийдвэрлэхдээ Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, эрх бүхий

---

байгууллагаас баталсан журам, Компанийн дүрэм, журамд нийцүүлэн шийдвэрлэх үүрэгтэй.

- 7.4. Компани нь Хөтөлбөрийн 6.2 дахь хэсэгт заасан санал хүсэлт, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн тухайгаа хөрөнгө оруулагчийн цахим шуудангийн хаягаар, утсаар холбогдон өгөх, эсхүл бичгээр хүргүүлнэ.

### **НАЙМ. ХАРИУЦЛАГА**

- 8.1. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь хөрөнгө оруулагчаас ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай Компанийн ТУЗ-д тухай бүр тайлагнан ажиллана.
- 8.2. Энэхүү хөтөлбөрийг зөрчсөн этгээдэд Компанийн тухай хуулийн болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэх бөгөөд Компанид учирсан хохирлыг буруутай этгээд хариуцна.

### **ЕС. ХЯНАЛТ**

- 9.1. Хөтөлбөрийн хэрэгжилтэд ТУЗ-ийн дэргэд дотоод аудитор хяналт тавьж ажиллах бөгөөд хэрэгжилтийн талаар ТУЗ-ийн ээлжит хурлаар танилцуулна. Шаардлагатай тохиолдолд тухай бүр цахим шуудан, эсхүл ээлжит бус хурлаар танилцуулна.
- 9.2. ТУЗ-с хөтөлбөрийн хэрэгжитийг хангуулах, сайжруулах зөвлөмжийг гүйцэтгэх удирдлагад хүргүүлнэ.